



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 408

Баянмөнх сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны өвөлжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор хивэг, тэжээл худалдан авах зардалд 8,000,000 (найман сая), тээвэрлэлтийн зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 9,000,000 (есөн сая) төгрөгийг Гамшгийн эрсдлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Н.Батаа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.НЯМДАВАА

